



# ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2018.07.09, ДАВАА ~ №136 (935)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000₮

## Засгийн газрын хуулийн төсөл мөрийн хөтөлбөрөө үгүйсгэжээ

Зохиргааны шүүхэд ялагдаад буй 10 хэргээ хаахын тулд ЗЕХ-г “оролдож” байна. > 2



Бизнес, эдийн засгийн төрөлжсөн сувар Financial Times-ийн нийтлэлүүдийг албан ёсны эрхтэйгээр хүргэж байна.

## Монголын эдийн засгийн бүтэц эмзэг хэвээр байна

Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулахад анхаарах хэрэгтэй гэв. > 5

ZGM DAILY

## Hysterical biography of lawmakers

Mongolian Parliament from time to time pays too much attention to minor issues. > 6

### ОНЦЛОХ

#### УЛС ТӨР

Авлигатай тэмцэх асуудлаарх олон улсын хурал аравдугаар сард Монголд болно.  
**У.Хүрэлсүх** Засгийн газрын Хүндэт өргөмжлөлийг зарим иргэдэд гардуулав.

#### ЭДИЙН ЗАСАГ

Инфляц энэ онд төв банкны зорилтот түвшинд байхаар байна.  
**Монгол Улсын ДНБ 2018 онд** зургаан хувиар өсөх төлөвтэйг Дэлхийн банк онцлов.

#### НИЙГЭМ

Улсын баяр наадмаар 557 замын цагдаа өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллана.  
**Н2 визний хүрээнд АНУ руу** ажиллах Монголын иргэд гарч эхэлжээ.

#### ДЭЛХИЙ

**АНУ тарифын “цээрлүүлэх** арга хэмжээ” авсны хариуд БНХАУ ижил арга хэмжээ авав.  
**Пакистан валютын хямралаас** сэргийлэхийн тулд Хятадын зээлд тулгуурлаж байна.



Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД У.ХҮРЭЛСҮХИЙН ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДАМД ИЛГЭЭХ МЭНДЧИЛГЭЭ

Уудам эх орныхоо өнцөг булан бүрт амьдарч буй  
Уужим эх дэлхийн дөрвөн зүг найман зовхист тархан суугаа  
Эх орон нэгт, элэг нэгт нийт Монголчуудаа

Та бүхэндээ Тулгар төрийн 2227 жил, Их Монгол улс байгуулагдсаны 812 жил, Ардын хувьсгалын түүхт 97 жилийн ой, Үндэсний их баяр наадмын мэндийг өргөн дэвшүүлье.

Монгол түмний баатарлаг түүхийн тод илэрхийлэл, өнө эртний соёл, төрт ёсны үнэт өв уламжлалтай дэлхийд ганцхан Монгол наадам дэнж хотолзуулан эхэллээ. Алдар суугаараа ертөнцийг тамгалсан аугаа их өвөг дээдсийн минь харвасан сумных нь эрч хариагүй, хурдан хүлгийнх нь шандас цуцаагүй, эрэмгий дайчдынх нь гал цог бөхөөгүйн гэрч нь гайхамшигт Монгол наадам билээ.

Хүчит бөхчүүд нь гарьд магнай, шандаст хүлгүүд нь тод магнай, мэргэн харваачид нь цэц магнай, төрийн сүлдээ цэнгүүлж түмэн олноороо босоо хийморьтой сайхан наадаарай.

Айл өрх бүрийн хойморт аз жаргал, баяр баясал цалгиж, хүн бүрийн сэтгэл зүрхэнд энэрэл нигүүлслийн гэгээ мөнхөд бадамлаж байх болтугай.

Морин дэл дээр ассан Монгол хүний хийморь галын дөл шигээ өөдөө байг.  
Монгол эх орон минь ганхашгүй бат мандан бадрах болтугай.  
Монгол түмэн минь дэнж хотойтол сайхан наадаарай.



Эх орондоо 6 жил  
үнэ цэнийг бүтээлцсэн

2013 оны 7 сарын 9 нд

Зэсийн баяжмал ачсан анхны 16 машины цуваа Гашуун сухайтын боомт руу хөдлөв.

2015 оны 2 сарын 18

1,000,000 дахь тонн зэсийн баяжмалаа экспортлов.

2017 оны 5 сарын 21

3,000,000 дахь тонн зэсийн баяжмалаа экспортлов.

2018 оны 07 сарын 09

Өнгөрсөн таван жилийн хугацаанд ойролцоогоор 4,000,000 тонн зэсийн баяжмал экспортлов.

## ТАВАН ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНД ХҮРГЭЭ!

2013 оны 07 сарын 09-д зэсийн баяжмалаа анх экспортолсноос хойш таван жилийг ардаа үдэн, өнөөдөр бид 15,000 гаруй чадварлаг залуусын гараар бүтээсэн дэлхийд өрсөлдөхүйц монгол уурхайг, монгол боловсон хүчнийг, монгол бүтээгдэхүүнийг хэдийнээ бий болгож чаджээ.

Эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс бүтээлцэнэ.

OTMongolia OTMongolia OTMongolia Oyu Tolgoi





Улс төр

# Засгийн газрын хуулийн төсөл мөрийн хөтөлбөрөө үгүйсгэжээ



2017 онд иргэн, ААН-ээс Засгийн газар түүний харьяа байгууллагатай холбоотой 1772 өргөдөл, гомдол гаргасны 1060-ыг нь Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэж, иргэдэд хохирлоо нөхөх боломж олгожээ.

Б.Батдорж / ЗГМ ©

**Захиргааны шүүхэд ялагдаад буй 10 хэргээ хаахын тулд ЗЕХ-г “оролдож” байна**

Г.Билгүүн  
ЗГМ

Засгийн газраас өргөн барьсан Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг парламент хэлэлцсэн ч, эсэргүүцэлтэй тулгарч завсарлага аваад байгаа.

Хууль зүй, дотоод хэргийн яамны боловсруулсан “даварсан” хуулийн төслийг УИХ-ын гишүүд иргэний эрхийг бүдүүлгээр зөрчсөн гэж үзээд өргөн барьснаар нь хүлээж авах боломжгүй гэдэг нь ойлгомжтой болсон. Мөн Монголын хуульчдын холбооноос хүргүүлсэн зөвлөмжийн дагуу

ХЗБХ-ны гишүүд дэг төслийг санаачлагчид нь буцаах асуудал ч яригдаж байгаа. Харин сайд Ц.Нямдорж шазуур зууж, өөрийн хуулиа хамгаалах дараагийн хувилбарт шилжсэн талаар хуульчид ярьж байна. Тэрбээр нийгэм даяар эсэргүүцэж байгаа ЗЕХ-ийн нэмэлт өөрчлөлтийг татаж авалгүй хоёр ч хувилбарыг дахин дэвшүүлэх бололтой. Эхнийх нь ЗЕХ-аар Захиргааны хэргийн шүүхэд хамаарах Засгийн газрын шийдвэртэй холбоотой маргааныг “иргэний” журмаар шийдүүлэх хуучин тогтолцоот хувилбарыг УИХ-ын намрын чуулганд өргөн барих магадлал бий. Өөрөөр хэлбэл, Захиргааны ерөнхий хууль батлагдахаас өмнө Засгийн газрын шийдвэртэй холбоотой маргааныг Иргэний хуулиар шийдвэрлэдэг байсан хэлбэр рүү ухралт хийнэ гэсэн үг. Энэ тохиолдолд иргэн, ААН-ийн талд шийдвэр гарч байсан нь тун бага. Учир нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар иргэний хэргийн шүүгч

Засгийн газрын шийдвэртэй холбоотой маргаанд нотлох баримтыг нэхэн магадлалгүй зөвхөн гаргаж өгсөн материалд тулгуурлан шийдвэрлэдэг. Энэ нь шүүгчийн шударга дэнсээс үл шалтгаалан Засгийн газар ялалт байгуулах гол мэх, дэгээ байсан. Үүнийг л залруулахын тулд УИХ Захиргааны ерөнхий хуулийг 2015 онд баталж, Захиргааны хэргийн шүүхээр Засгийн газрын үйл ажиллагааг хязгаарлаж ирсэн тухай хуульчид сануулж буй. Ийн Засгийн газрын дээрхгүй шийдвэрийн балагт өртсөн иргэн, ААН хохирлоо барагдуулах боломжтой болсон.

Өнгөрсөн хугацаанд Засгийн газар түүний харьяа байгууллагуудын буруу шийдвэрийн улмаас иргэд ААН-д 24 тэрбум төгрөгийн хохирол учирсныг Захиргааны хэргийн шүүх нотолж, нөхөн төлбөр гаргуулжээ. 2017 онд иргэн, ААН-ээс Засгийн газар түүний харьяа байгууллагатай холбоотой 1772 өргөдөл, гомдол гаргасан байдаг. Захиргааны

шүүх 1060 хэргийг хянан шийдвэрлэж иргэдэд хохирлоо нөхөх боломж олгосон байна. Үүний 19 нь шууд Засгийн

ЗГМ: тодруулга

## Н.Энхбаяр: О.Баасанхүү уучлалт гуйхгүй бол дүрмийн өөрчлөлтөөр намаас хасна

**Хэнтийн нөхөн сонгуульд туйлын хариуцлагатай оролцоно**

П.Батбөх  
ЗГМ



МАХН-ын дарга Н.Энхбаяраас цаг үеийн асуудлаар дараах тодруулгыг авлаа. Тус намын удирдлага болон дүрмийн өөрчлөлтийн талаар УДШ-д Н.Энхбаяр, УИХ-ын гишүүн О.Баасанхүү нар тус тусдаа хандаад байгаа билээ.

-МАХН-ын дүрмийн өөрчлөлтийг Улсын дээд шүүх бүртгэхээс татгалзаад байгаа. Удахгүй Хэнтийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль болох гэж байна. Танай намын дотоод зөрчил энэ удаагийн сонгуульд

газрын шийдвэртэй холбоотой маргаан бөгөөд 10-т нь Засгийн газар ялагдал хүлээгээд байгаа юм. Ийм учраас ялагдлаа цайруулахын тулд Ц.Нямдорж ЗЕХ-д өөрчлөлт оруулахаар “хүчиндэж” байх талтай. ЗЕХ-д Ц.Нямдоржийн зүтгүүлж буй хуулийн заалт орчихвол дээрх 10 хэрэг шууд хаагдах учир ийн чичрээд байгааг үгүйсгэхгүй.

Ц.Нямдорж сайд хүч түрж иргэдийн эрхийг булаах оролдлого бүтэхгүй гэдгийг ойлгосон ч дараагийн хувилбарыг бас төлөвлөчихсөн гэнэ. Тэр нь ЗЕХ-д хамаарах субъектийг цөөлөх шийдэл. Өөрөөр хэлбэл, УИХ-ын хаврын чуулганаар өргөн барьсан Засгийн газар хэмжээгүй эрхтэй болох төслөөс агентлаг, аймаг, сум, дүүргийн захиргааны шийдвэрийг хасах хувилбар юм. Ингэснээр Засгийн газар, яамдын шийдвэртэй холбоотой маргаан л ЗЕХ-ийн гадна үлдэнэ гэсэн үг. Захиргааны хэргийн шүүхэд ялагдаад байгаа 10 хэргийн дийлэнх нь энэ хоёртой холбоотой шийдвэр учраас

анхны зорилгод нь бараг нийцэх хувилбар л даа.

Гэхдээ Засгийн газрын ЗЕХ-д өөрчлөлт оруулж, шүүхэд ялагдсан 10 хэргээ аврах ажиллагаа нь мөрийн хөтөлбөрөө үгүйсгэсэн үйлдэл болж байгааг ХЗДХ-ийн сайд мэддэг болов уу. 2016 онд дэвшүүлсэн МАН-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрт багтаж улмаар Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан “Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангаж, захиргааны байгууллагаас иргэдийн эрхийг аливаа хэлбэрээр зөрчихгүй байх нөхцөлийг хангана” гэсэн заалт бий. Харин өдгөө Засгийн газар, ХЗДХ-ийн сайд нь мөрийн хөтөлбөрийнхөө эсрэг “буруу ишилсэн сүх” лугаа улайрч явна.

Хэрэв Засгийн газар ЗЕХ-д өөрчлөлт оруулж 10 хэргээ хаах зорилгоосоо буцахгүй гэвэл мөрийн хөтөлбөрийнхөө эсрэг ажилласан Засгийн хувь заяа хаашаа ч эргэж мэдэх юм. “Жоомоо устгах гээд гэрээ шатаачихдаг” онигоо энэ засгийн үед биеллээ олох вий. [ЗГМ]

оны Ерөнхийлөгчийн сонгуулиар С.Ганбаатарын эсрэг тууштай явсан.

-Намын дүрмийн өөрчлөлтийг Улсын дээд шүүх хүлээгээд авчихвал О.Баасанхүүг намаас хассанд тооцох уу?

-Хэрэв О.Баасанхүү гишүүн миний буруу гэж уучлалт гуйгаад, намынхаа эсрэг ажиллахгүй, намынхаа нэр дэвшигчийг дэмжиж ажиллана гэдгээ албан ёсоор мэдэгдвэл бид түүнийг яалаа гэж “чи зайл” гэж хэлэх вэ. Тэгэхгүй энэ хэвээрээ яваад байх юм бол нам өөрийн “төрүүлсэн” гишүүндээ дарлуулаад байхыг хүсэхгүй.

-УИХ-ын гишүүн О.Баасанхүүд МАХН-ын Их чуулганд оролцох урилга хүргүүлсэн үү?

-Бид хурал болгоноор урилга хүргүүлдэг. Ирэхгүй байгаа. Тиймээс л намаас хөөгдөх эсэх нь өөрөөс нь шалтгаална.

-Та Хэнтийн нөхөн сонгуульд нэр дэвших бодолтой байгаа юу?

-2012 онд намайг боловсролгүй, 2016 онд хүмүүжилгүй гээд оролцуулаагүй. Одоо харин тоглоом тоотой нь дээр байлгүй. Яахыг хэлж мэдэхгүй юм. Хэнтий аймагт хэнийг нэр дэвшүүлэхийг намын Бага чуулганаар шийдвэрлэнэ. Харин МАХН энэ нөхөн сонгуульд туйлын хариуцлагатай оролцохоор бэлтгэж байна. [ЗГМ]

## [ЗГМ СОНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга  
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Ерөнхий эрхлэгч  
Баатарын ДУЛАМХОРЛОО

Зөвлөх  
Шатарбалын ДАВААДОРЖ

Орлогч эрхлэгч  
Лхагважавын СУГАРМАА  
Утас: 99903584

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба  
Эдитор Б.Энхжаргал  
Утас: 99901621

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба  
Эдитор Б.Баяртотгох  
Утас: 99901532

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба  
Эдитор Г.Баярсайхан  
Утас: 99903574

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903581  
99903578  
99909472  
99907843

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
I хороо, Энхтайвны өргөн чөлөө,  
“Блс Скэй тауэр” 407 тоот  
Улсын бүртгэлийн дугаар. 1024  
Утас: 70103131,  
Факс: 7010606

ЦАХИМ ХУВИЛБАР  
ubinfo.mn

Дугаарын удирдагч  
Г.Баярсайхан

86580004029112 00935

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018. 07. 09ны өдөр

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:** БК3-420-140-10С зуух №4-ын тоосон системийн их засвар хийж гүйцэтгэх

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР:** ТЗ-2018/092\

**“ДЦС-4” ТӨХК** нь эрх бүхий тендерт оролцогчдоос “БК3-420-140-10С зуух №4-ын тоосон системийн их засварын ажил хийж гүйцэтгэх” тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 100.000 /Зуун мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилийн жил тус бүрийн борлуулалтын орлого нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. 2016,2017 он тус бүрээр
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.
- Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** сүүлийн 2 жил. 2016, 2017он
- Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Тендерт санал болгосон үнийн дүнгээс багагүй байх /2016, 2017 он /
- Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх:** Шаардлагатай /80кгх/см2-аас дээш даралттай зуухны угсралт/

Тендерийн хамт 4,050,500 дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгааг хүлээн зөвшөөрнө.

Хүчинтэй байх хугацаа: 2018 оны 10 дугаар сарын 22 -ний өдөр дуустал

Тендерийг 2018 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн 10.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 08 дугаар сарын 09 -ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй, Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж, “ДЦС-4” ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар, 310 тоот өрөө Худалдан авах ажиллагааны хэлтэс Утас 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс 7018-1309 7000-1357

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018.07.09ны өдөр

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:** Хаягдал конденсатыг цэвэрлэж дахин ашиглах үр ашгийг нэмэгдүүлэх материал нийлүүлэх

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР:** АУ-2018/55

**“ДЦС-4” ТӨХК** нь эрх бүхий тендерт оролцогчдоос “Хаягдал конденсатыг цэвэрлэж дахин ашиглах үр ашгийг нэмэгдүүлэх материал нийлүүлэх” тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 50.000 /Тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилийн жил тус бүрийн борлуулалтын орлого нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. 2016,2017 он тус бүрээр
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.
- Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** сүүлийн 2 жил. 2016, 2017он
- Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Тендерт санал болгосон үнийн дүнгээс багагүй байх /2016, 2017 он /
- Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх:** Шаардлагагүй

Тендерийн хамт 2,000,000 дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгааг хүлээн зөвшөөрнө.

Хүчинтэй байх хугацаа: 2018 оны 10 дугаар сарын 22 -ний өдөр дуустал Тендерийг 2018 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн 10.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 08 дугаар сарын 09 -ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй, Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж, “ДЦС-4” ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар, 310 тоот өрөө Худалдан авах ажиллагааны хэлтэс Утас 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс 7018-1309 7000-1357



# ЗГМ: Сэдэв

## Монголчууд аялал жуулчлалын оргил үеэ ашиглаж чадахгүй байна

З.Цэлмэг  
@tselmegZGM

Үндэсний их баяр наадмын бэлтгэлээ ид хангаж буй эдгээр өдрүүдэд манай аялал жуулчлалын оргил үе тохиож байна. Албаны эх сурвалжийн мэдээлж буйгаар энэ жил долдугаар сард ирэх жуулчдын тоо 90 мянга хүрэх төлөвтэй байгаа нь 2017 оныхоос 10 хувиар өсөж буй юм. Бүр тодорхой хэлбэл, манай улсын жилд хүлээн авдаг жуулчдын 20 орчим хувь нь зөвхөн долдугаар сард улсын болоод бэсрэг наадам үзэх зорилгоор ирдэг байна. Харин тур операторууд наадмын багц аяллыг дунджаар 2000 ам.доллараар борлуулдаг. Ингээд тооцвол үндсэндээ наадам гэдэг брэнд манай улсад энэ жил 180 сая ам.доллар татаж байна гэсэн үг. Энэ мөнгөнөөс тээвэр, зочид буудал, үзвэр үйлчилгээ гээд 13 салбар хүртдэг. Ийм хэмжээнд хүрэхийн тулд тур операторууд жил бүр гадаад сурталчилгаандаа олон сая төгрөг хаядаг. Зөвхөн “ITB Berlin”-д оролцохын тулд нэг компани талбайн түрээсэнд дөрвөн өдрийн 5000 евро төлдөг. Үүнээс гадна тээвэр, зочид буудал, сурталчилгааны тараах материал, хоол унд гээд бүх зардлаа өөрсдөө гаргадаг болохыг Монголын аялал жуулчлалын холбооны төлөөлөл ярилаа. Харин байгаа ганц брэнд бүтээгдэхүүн болох наадмаа сурталчлахын тулд улсаас нэг ч төгрөг зарцуулдаггүй аж.

## Наадмын гадаад сурталчилгаанд улс нэг ч төгрөг зарцуулдаггүй

Аялал жуулчлал нь орлогын хүртээмж сайтай, ядуурлыг бууруулж, амьжиргааг дэмжихэд тун чухал үүрэг гүйцэтгэдэг учраас улс орнууд жуулчдыг визний хамгийн хөнгөлөлттэй нөхцөл, хамгийн найрсаг үйлчилгээ, тав тухтай орчноор татах гэж өрсөлддөг. Чадал тэнхээтэй эдийн засгууд бол дуу алдам том бүтээн байгуулалт өрнүүлж буй. Бид ч гэсэн 2020 он гэхэд нэг сая жуулчин авна гэсэн том зорилго тавьсан атлаа ачир дээрээ “Манайд ирж наадам үзвэл үз, байвал бай” гэсэн шиг гэдгийж



С.Батсайхан / ЗГМ©

# Наадам бол Монголыг дэлхийд таниулах цорын ганц брэнд

сууна. Харин эл гэдгэр зангийн горыг одоо тур операторууд харилцагчдынхаа өмнө нүүрээ уялзуулан амсаж буй бол алсдаа Монголд сурталчлах ч брэнд байхгүй болж, хөгжлийн гурван тулгуурын нэг салбар нь илтэд доголдох шинжтэй.

Өнгөрсөн долоо хоногт наадмын нээлтийн тасалбар жуулчдад хүрэлцэхгүй байгаа талаар Монголын аялал жуулчлалын холбоо мэдээлэл хийж, харамсалтай ч гэмээр тоо баримтууд дурдсан юм. “Наадам” брэндийн эрэлт нийлүүлэлтээсээ 4-5 дахин давснаар захиалга өгсөн 10 жуулчин тутмын хоёр нь нээлт үзэж чадахгүй, төв цэнгэлдэхийн гадна үлдэхээс өөр сонголтгүй болжээ. Наадмын нээлт үзэх захиалгаа өгч, баталгаажуулсан 11390 жуулчин байгаа ч Үндэсний их баяр наадам зохион байгуулах хорооноос ердөө 2500 тасалбар хуваарилсан аж. Тиймээс зарим тур операторын гадаад түнш нь харилцаагаа таслах, гэрээний нөхөн төлбөр төлөх, цаашлаад Монголын талаар сөрөг сурталчилгаа дэлхий нийтэд түгэж, наадам гэх брэнд зах зээлгүй болох бодит эрсдэл тулаад буйг салбарынхан онцолсон юм. Үндэсний их баяр наадам зохион байгуулах хорооны дарга Ө.Энхтүвшинд хүргүүлсэн

албан бичигтээ “Манай улсыг сурталчлах, аялал зохион байгуулах компаниудын үйл ажиллагааг бодитоор боогдуулж, “Монголын аялал баталгагүй, үйлчилгээгүй” гэсэн муу имиж олон улсад бүрдүүлж, нэг жуулчнаас олох орлого, ажлын байрыг алдаж, үндэсний татвар төлөгч компаниудын нэр хүнд, бизнесийг хумьсан бодит эрсдэл үүсгэж байна. Үүний улмаас манай улсад орж ирэх 20 сая ам.доллар орхигдож, 1000 гаруй ажлын байр алга болж, цаашдаа жуулчдын тоо бүхэлдээ татрахад хүрч байгаа юм. Тиймээс суудлын тоог ядаж 1000-аар нэмэгдүүлж, 3500 суудал олгохыг дэмжинэ үү” хэмээсэн байв. Хэдийгээр уг шаардлагыг зохион байгуулагчид хүлээн авч, 500 суудал нэмж хуваарилахаар шийдвэрлэсэн ч ердөө 100 тасалбарыг л нийслэлийн Аялал жуулчлалын газраас өгсөн гэдгийг Монголын аялал жуулчлалын холбооны дэд тэргүүн Б.Отгонбаяр хэлсэн юм. Уг нь багтаамж сайтай ганц цэнгэлдэх хүрээлэн босгоход л жилийн жилд сөхөгддөг энэ асуудлыг шийднэ. Гэвч Монгол наадам цогцолбор байгуулна гэж ярьсаар 10 жил өнгөрлөө.

Угтаа үндэсний их баяр наадам гэдэг бол олон улсын зах зээл дээр Монголыг сурталчлах ялгарал, ахархан хугацаатай аялал

жуулчлалын оргил үе. Түүнээс биш монголчуудын гэдгэр, хэнэггүй, хэлсэндээ хүрдэггүй, бусдад түвэг

### БАЙР СУУРЬ

#### НЭЭЛТИЙГ ХОЁР ӨДӨР ХИЙХ САНАЛ ТАВЬСАН Ч ХҮЛЭЭЖ АВААГҮЙ

*БОАЖЯ-ны Аялал жуулчлалын газрын ахлах мэргэжилтэн С.Баясгалан*

-Яамны зүгээс тасалбарын хуваарилалтад оролцох эрх зүйн үндэс байхгүй ч аль болох олон жуулчин хүлээж авах бодлого баримталдаг. Бид суудал хүрэлцэхгүй байгаа бол нээлтээ хоёр өдөр хийх санал

#### ТААГҮЙ СЭТГЭГДЭЛТЭЙ ҮЛДСЭН БОЛ ТӨЛБӨРӨӨ 100 ХУВЬ БУЦААЖ АВДАГ

*МАЖХ-ны дэд тэргүүн Б.Отгонбаяр*

-Наадам бол хугацаа нь тодорхой байдаг тул захиалга авдаг хамгийн гол сурталчилгаа шүү дээ. Аймгуудын наадам хугацаа нь тодорхой биш байдаг тул бид долдугаар сар гартал хүлээдэг. Гэтэл энэ салбарыг авч яваа ТОП 50 компанийн хэрэглэгч,

чирэгдэл учруулдаг муухай занг харуулах сөрөг сурталчилгаа биш баймаарсан. Тиймээс жуулчдад

тавьсан. Гэвч энэ жил төсөв хуваарилаагүй тул хоёр өдөр хийх боломжгүй гэж зохион байгуулах комисс мэдэгдсэн. Харин ирэх жил наадмын нээлтийг хоёр өдөр болгож, хоёр дахь өдрийн зардлыг нь салбарын яамны төсөвт тусгахаар явж байна. Гэхдээ энэ шийдэл дэмжигдэх эсэхийг нь мэдэхгүй. 10 жил яригдаж байгаа Монгол наадам цогцолборыг зайлшгүй барих шаардлагатай байна. Тэгэхгүй бол манай аялал жуулчлалын компаниуд хөтөлбөрт

хандах хандлагаа өөрчилье, бас өөрсдөө ч муу муухайгаа экспортолохоо болье. [ЗГМ]

орсон бүтээгдэхүүн, үйлчилгээгээ үзүүлж чадахгүй болохоор гэрээ цуцлагдах, дахин байгуулах нөхцөл үүсэхгүй, нэр хүнд нь унаж, гадаад хамтын ажиллагаа нь эрсдэлд орж байна. Цаашлаад наадам гэдэг бүтээгдэхүүнээ олон улсын зах зээл дээр зарах нүүргүй болж байгаа юм.

Өмнө нь долдугаар сард 10 мянган жуулчин ирдэг байсан бол хувийн хэвшлийн зүтгэлийн үр дүнд ес дахин их жуулчин ирдэг болоод байна.

харилцагчид наадмын нээлтийг цагаан сандал дээр суугаад тав тухгүй үзсэн шалтгаанаас болж хамтын ажиллагаагаа цуцалсан асуудал нэлээд гарсан. Зөвхөн наадам үзэх гэж ирээд ийм таагүй сэтгэгдэлтэй үлдсэн бол жуулчид төлбөрөө 100 хувь буцааж авдаг.

Өмнө нь би жуулчид авч явдаг байхдаа “Манай улс та нарыг 2-3 жилийн дараа ирэхэд том цэнгэлдэх хүрээлэнтэй болж, өөр гоё хөтөлбөрөөр угтана” гэж ярьдаг байлаа. Гэтэл одоо ч

гэсэн энэ асуудлаа л ярьж байна. Том цэнгэлдэх хүрээлэнтэй болж байж энэ асуудал цэгцэрнэ. Аялал жуулчлалын салбарт ийм асуудал цаашид гаргахгүйн тулд компаниуд өрсдөө мөнгө босгоё, эсвэл төрд зардлыг нь хандивлаад шинэ цэнгэлдэх хүрээлэнтэй больё гэсэн байр суурь баримталж байна. Шинэ цэнгэлдэхтэй болбол наадам гэлтгүй бусад үед ч янз бүрийн арга хэмжээ зохион байгуулж, аяллын улирлаа уртасгах боломжтой.



### ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ШАЛГАЛТЫН БҮРТГЭЛ ЭХЭЛЛЭЭ

Монголын Хуульчдын холбооноос Хуульчийн мэргэжлийн шалгалтыг 2018 оны есдүгээр сарын 26, 27, 28-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулахаар товлосоо.

Хуульчийн мэргэжлийн шалгалтын бүртгэл 2018 оны долдугаар сарын 09-ний өдрийн 13:00 цагт эхэлж, 2018 оны наймдугаар сарын 26-ны өдрийн 00:00 цагт дуусах бөгөөд бүртгэлийг <https://burtgel.mglbar.mn/> цахим хаягаар явуулна.

Хуульчийн мэргэжлийн шалгалтыг сорилго, бодлого гэсэн дарааллаар авна. Сорилгын шалгалт нь 200 асуултаас бүрдэх бөгөөд үргэлжлэх хугацаа 200 минут, бодлогын шалгалтын нэг бодлогыг бодох хугацаа 150 минут байна.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хуульчийн мэргэжлийн шалгалтын журам, Хуульчийн мэргэжлийн дадлагад тооцох журам болон шалгалтад бүртгүүлэх заавартай [www.mglbar.mn](http://www.mglbar.mn) (Монголын Хуульчдын холбооны албан ёсны цахим хуудас), <https://burtgel.mglbar.mn/> (Шалгалтын бүртгэлийн цахим хаяг) цахим хаягт хандан танилцах боломжтой.

**Холбоо барих: 70116364**  
(Хуульчийн мэргэжлийн шалгалтын хороо хариуцсан мэргэжилтэн)

**МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБОО**  
**ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ШАЛГАЛТЫН АСУУДАЛ**  
**ЭРХЭЛСЭН ХОРОО**

### С.ЦОГТБАЯР ЗУРЖ БАЙНА





Наадам-2018

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ХӨТӨЛБӨР



**7 ДУГААР САРЫН 9. ДАВАА**

**9.00-19.00** Хүүхдийн сурын харваа (Сурын талбайд)

**7 ДУГААР САРЫН 10. МЯГМАР**

**08.00-11.00** Хязаалан насны морьдын уралдаан (Хүй долоон худагт)

**08.00** Шагайн харвааны хэсгийн харваа (Шагайн асарт)

**08.30** Үндэсний сурын хана харвааны эхэн өрөг (Сурын талбайд)

**10.00** Төрийн далбааны өдөрт зориулсан ёслол (Жанжин Д.Сүхбаатарын талбайд)

**11:00** “Монголын сайхан орон” шилдэг бүтээлийн үзэсгэлэн (Монголын Урчуудын эвлэлийн хорооны үзэсгэлэнгийн танхим)

**13.00-13.30** Жанжин Д.Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөх, Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүлэх ёслол (Жанжин Д.Сүхбаатарын талбайд)



**14.00** Дээлтэй Монгол наадам (Жанжин Д.Сүхбаатарын талбайд)

**14.00-16.30** Шүдлэн насны морьдын уралдаан (Хүй долоон худагт)

**14.30-20.30** Үндэсний сурын хана харвааны дунд өрөг (Сурын талбайд)

**15.00, 18.00** Тулгар төрийн 2227, Их Монгол Улсын 812, Ардын хувьсгалын 97 жилийн ой, Үндэсний их баяр наадмын Төрийн хүндэтгэлийн концерт (Соёлын төв өргөөнд)

**20.00** Монгол Улсын Төрийн тугийг цэнгүүлэх ёслол Төрийн ордон, (Жанжин Д.Сүхбаатарын талбайд)

**7 ДУГААР САРЫН 11. ЛХАГВА**

**08.00-11.40** Азарганы уралдаан (Хүй долоон худагт)

**08.00** Шагайн харвааны хагас шигшээ харваа (Шагайн асарт)



**11.00** Монгол Улсын Төрийн тугийг Төв цэнгэлдэх хүрээлэнд залах ёслол

**11.10** Тулгар төрийн 2227, Их Монгол Улсын 812, Ардын хувьсгалын 97 жилийн ой, Үндэсний их баяр наадмын ажиллагааг Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга нээж, Төрийн туганд хүндэтгэл үзүүлнэ.



**11.20** Үндэсний их баяр наадмын нээлтийн ажиллагаа /тусгай хөтөлбөрөөр/ (Төв цэнгэлдэх хүрээлэнд)

**11.30** Шагайн харвааны тэмцээний нээлтийн ажиллагаа (Шагайн асарт)

**12.30** Шагайн харвааны хагас шигшээ харваа (Шагайн асарт)

**13.00-17.00** Хүчит бөхийн барилдааны нэгийн даваа (Төв цэнгэлдэх хүрээлэнд)

**13.00-16.00** Хүүхдийн барилдааны нэгийн даваа (Төв цэнгэлдэх хүрээлэнд)

**13.30-14.00** Үндэсний сурын нэгдсэн үзүүлэх харваа (Сурын талбайд)

**14.00** Хүй долоон худгийн наадмын нээлтийн ажиллагаа /тусгай хөтөлбөрөөр/ (Хүй долоон худагт)

**14.00-17.00** Их насны морьдын уралдаан (Хүй долоон худагт)

**14.30-17.30** Үндэсний сурын хана харвааны адаг өрөг (Сурын талбайд)

**16.20-18.00** Хүүхдийн барилдааны хоёрын даваа (Төв цэнгэлдэх хүрээлэнд)

**17.10-20.00** Хүчит бөхийн барилдааны хоёрын даваа (Төв цэнгэлдэх хүрээлэнд)

**17.30-21.30** Үндэсний сурын хасаа харвааны эхэн өрөг (Сурын талбайд)

**21.00-23.00** “Улаанбаатарын үдэш” цэнгүүн (Жанжин Д.Сүхбаатарын талбайд)

**23.00** Баяр наадмын ёслолын буудлага (Жанжин Д.Сүхбаатарын талбай, Баянхошуу, Маахуур толгой, 7-н буудал орчим)

**7 ДУГААР САРЫН 12. ПҮРЭВ**

**07.00-09.20** Соёолон насны морьдын уралдаан (Хүй долоон худагт)



**08.00** Шагайн харвааны шигшээ харваа (Шагайн асарт)

**07.00-12.00** Үндэсний сурын хасаа харвааны дунд өрөг (Сурын талбайд)

**09.00-11.00** Хүчит бөхийн барилдааны гурвын даваа (Төв цэнгэлдэх хүрээлэнд)

**10.00-11.00** Хүүхдийн барилдааны гурвын даваа (Төв цэнгэлдэх хүрээлэнд)

**10.30-12.30** Дааганы уралдаан (Хүй долоон худагт)

**11.20-12.40** Хүчит бөхийн барилдааны дөрвийн даваа (Төв цэнгэлдэх хүрээлэнд)

**11.20-12.40** Хүүхдийн барилдааны дөрвийн даваа (Төв цэнгэлдэх хүрээлэнд)

**12.00-14.00** Үндэсний сурын хасаа харвааны адаг өрөг (Сурын талбайд)

**13.00** Шагайн харвааны харваачдад шагнал гардуулах ёслол (Шагайн асарт)

**14.00-14.30** Үндэсний сурын түрүү тодруулах шилдэг 8 харваачийн харваа (Сурын талбайд)

**14.30-15.10** Хүчит бөхийн барилдааны тавын даваа (Төв цэнгэлдэх хүрээлэнд)

**15.20-15.30** Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга үндэсний сур, шагайн харваанд түрүүлсэн харваачдад шагнал гардуулна. Улсын цолны болзол хангасан сурын харваачдад цол олгож, үнэмлэх, энгэрийн тэмдэг гардуулна. (Төв цэнгэлдэх хүрээлэнд)

**15.40-16.20** Хүчит бөхийн барилдааны зургаагийн даваа (Төв цэнгэлдэх хүрээлэнд)

**15.20-16.00** Хүүхдийн барилдааны тавын даваа (Төв цэнгэлдэх хүрээлэнд)

**16.10-16.40** Түрүүлж, айрагдсан морьдын цол дуудаж, шагнал гардуулна. Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга хурдан морь унаач хүүхдүүдэд бэлэг гардуулна. (Төв цэнгэлдэх хүрээлэнд)

**16.20-16.40** Хүүхдийн барилдааны зургаагийн даваа (Төв цэнгэлдэх хүрээлэнд)

**16.40-17.20** Хүчит бөхийн барилдааны долоогийн даваа (Төв цэнгэлдэх хүрээлэнд)

**17.30-17.40** Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга “Улсын начин”, “Улсын харцага” цолны болзол хангасан бөхчүүдэд цол олгож, үнэмлэх, энгэрийн тэмдэг гардуулна. (Төв цэнгэлдэх хүрээлэнд)



**17.50-18.40** Хүчит бөхийн барилдааны наймын даваа (Төв цэнгэлдэх хүрээлэнд)

**18.30-19.00** Хүүхдийн барилдааны долоогийн даваа (Төв цэнгэлдэх хүрээлэнд)

**19.10-19.20** Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга “Улсын заан” цолны болзол хангасан бөхчүүдэд цол олгож, үнэмлэх, энгэрийн тэмдэг гардуулна. (Төв цэнгэлдэх хүрээлэнд)

**19.20-19.50** Хүчит бөхийн барилдааны есийн даваа (Төв цэнгэлдэх хүрээлэнд)

**19.50-20.00** Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга Үндэсний Их Баяр наадмын хүчит бөхийн барилдаанд түрүүлж, үзүүрлэсэн бөхчүүдэд цол олгож, үнэмлэх, энгэрийн тэмдэг, шагнал гардуулна. (Төв цэнгэлдэх хүрээлэнд)

**20.00** Тулгар төрийн 2227, Их Монгол Улсын 812, Ардын хувьсгалын 97 жилийн ой, Үндэсний их баяр наадмын ажиллагааг Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга хаана. (Төв цэнгэлдэх хүрээлэнд)

**20.10** Үндэсний Их Баяр наадмын хаалтын ажиллагаа, Монгол Улсын Төрийн тугийг Төв цэнгэлдэх хүрээлэнгээс Төрийн ордон руу залах ёслол

**21.00-23.00** “Монгол сонгодог” үдшийн цэнгүүн (Жанжин Д.Сүхбаатарын талбайд)

**ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО**

Машины зөвшөөрөл олгож эхлэв

Баяр наадмын үеэр иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор цагдаагийн нийт 557 алба хаагч, Хууль сахиулах их сургуулийн 85 сонсогч ажиллахаар болжээ.

Цагдаагийн байгууллагаас тээврийн хэрэгслийн зөвшөөрлийн талбайг ойролцоо дүүргээр нь ангилсан байна. Тухайлбал Г төрлийн зөвшөөрлийг СБД, СХД, БГД, ЧД-ийн чиглэлээс ирж буй иргэдэд зориулан Энхтайваны гүүрний зүүн дор байрлах “Усан парк”-ын зогсоолд, ХУД, БЗД-ийн чиглэлээс ирж буй иргэдэд зориулан Хурд хорооллын зүүн

талд байрлах “Суруга Монгол” ХХК-ийн зогсоолд байрлуулжээ.

Баяр наадам зохион байгуулах комисс мэдээлэл хийх үеэр ЦЕГ-ын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газрын дарга, туслах комиссар Ж.Амгалан “Баяр наадмын өдрүүдэд өндөржүүлсэн бэлэн байдалд шилжих бэлтгэл ажил хийгдэж дууслаа.

Нийт уяачид, наадамчин олонд санамж бичгүүдийг тарааж, бэлтгэл ажлыг хангасан. Морь дагах машины тоог цөөлсөн. Энэ жилийн баяр наадмаар нийт 12-16 машин морь дагана. Морины

комиссын ажиллах нөхцөлийг бүрдүүлж, түрүү морины хашаа руу олон машин зэрэг оруулахгүй. Түргэний машин, мал эмнэлгийг өргөөчилж өгсөн.

Цэнгэлдэх хүрээлэнд зөвхөн тасалбартай, мандаттай хүнийг л нэвтрүүлнэ” гэсэн юм.

Баяр наадмын үеэр хулгай болон бусад гэмт хэрэг гарах нь ихэсдэг тул иргэдийг сэрэмжтэй байхыг цагдаагийн байгууллагаас анхаарууллаа. Иргэд амралт зугаалгаар явахдаа хүүхдээ хараа хяналтгүй орхихгүй байхыг анхааруулсан байна. [ЗГМ]

Гадаад, дотоодын 600 сэтгүүлч ажиллана



С.Батсайхан / ЗГМӨ

Баяр наадам зохион байгуулах комиссын мэдээлснээр энэ жил хэвлэл мэдээллийн 600 гаруй ажилтан наадмыг сурвалжлах юм. Наадмыг МҮОНРТ, ТВ9, ТВ5, NTV, UBS, SPS зэрэг найман телевиз шууд дамжуулах ба гадаадын сурвалжлагчид мөн ажиллана.

Засгийн газрын ХМА-ны дарга Ц.Ганзориг “Өмнө нь баяр наадмын мандатыг Хүй долоон худаг, Төв цэнгэлдэх гэж хязгаарладаг байсан. Харин энэ жил энэхүү хязгаарлалтыг больсон.

Мөн энэ жил Төв цэнгэлдэх, Хүй долоон худагт хэвлэл мэдээллийн

ажилтнууддаа зориулж интернет сүлжээтэй, компьютертэй өрөө тусгайлан бэлэн болгосон.

Мандат гурван өнгөтэй байгаа. Цэнхэр мандат бүгдэд нээлттэй, улаан мандат нь шууд дамжуулж байгаа найман телевизийнх, ногоон нь тодорхой хязгаарлалттай” гэв. [ЗГМ]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 07 дугаар сарын 09 ны өдөр

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:**  
Ахуйн байр №1-н гадна болон дотор засвар хийлгэх

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР:** 63-2018/104-1

**“ДЦС-4” ТӨХК нь** эрх бүхий тендерт оролцогчдоос Ахуйн байр №1-н гадна болон дотор засвар хийлгэх” тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө **100.000 /Зуун мянга/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

**1. Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилийн жил тус бүрийн борлуулалтын орлого нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. 2016,2017 он тус бүрээр

**2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлийн хэмжээ:** Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.

**3. Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** сүүлийн 2 жил. 2016, 2017он

**4. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын турлага** ирүүлэх /2016, 2017 он/

**5. Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх:** “тийм” Барилга угсралт 2.1.1, заалтын дагуу

Тендерийн хамт **3,856,000** дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгааг хүлээн зөвшөөрнө.

Хүчинтэй байх хугацаа: **2018 оны 10 дугаар сарын 22 -ний өдөр дуустал**

Тендерийг **2018 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн 10.00** цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2018 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн 10 цаг 30 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй, Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж, “ДЦС-4” ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар, 310 тоот өрөө**  
**Худалдан авах ажиллагааны хэлтэс**  
**Утас 7018-1309, 7000-1357, 7017-1357,**  
**Факс 7018-1309 7000-1357**

ТОВЧХОН

» Тулгар төрийн 2227, Их Монгол Улсын 812, Ардын хувьсгалын 97 жилийн ой, Үндэсний их баяр наадамд нийт 2.7 тэрбум зарцуулна. Үүнээс нээлтийн ажиллагаанд 600 сая төгрөг төсөвлөжээ. Төв цэнгэлдэх хүрээлэнгийн 3000 гаруй суудлын тасалбарыг аялал жуулчлалын компаниудад тараана.

» Баяр наадмын үеэр худалдаа, хоолны үйлчилгээ үзүүлэх 400 зөвшөөрөл олгоно. Ингэхдээ тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудаас сонгон шалгаруулж, чанарын шаардлага хангахуйц стандартын тоног төхөөрөмж, хэрэгсэлтэй байхыг шаардах юм.

» Хурдан морины салбар хороо 30 хүний бүрэлдэхүүнтэй Хүй долоон худагт долдугаар сарын 9-нөөс эхлэн ажиллана. Хурдан морь уралдуулах ажилд 2.500-3.000 албан хаагч оролцоно. Энэ жил Монгол телевиз, ETV, TV9 телевиз хурдан морины уралдааныг шууд дамжуулна.

» Үндэсний их баяр наадам болон 21 аймгийн хэмжээнд уралдаанч хүүхдүүдийг хурууны хээгээр бүртгэж, цахим карт олгоно. Бүртгүүлэхэд эцэг эхийн зөвшөөрлийг заавал шаардана. Хүүхдийн бичиг баримтаар бүртгүүлдэг, насанд хүрээгүй хүүхэд уралдуулдаг, хүүхдийн эрх зөрчдөг байдлыг таслан зогсооно. Хүүхдийн даатгалын хураамжийг 100 мянга, нөхөн олговрын хэмжээг 20 сая хүртэл төгрөгөөр тогтоогоод байна.



Эдийн засаг

Монголын эдийн засгийн бүтэц эмзэг хэвээр байна

Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулахад анхаарах хэрэгтэй гэв

Б.Баяртогтох  
@bayartogkhZGM

Монголын эдийн засаг эргэн сэргэж буйг Дэлхийн банк цохон тэмдэглэв. Нүүрсний салбарын идэвхжил, хувийн хөрөнгө оруулалт, зах зээлийн орчин сайжирснаар эдийн засагт 2017 онд хүлээж байснаас хүчтэй сэргэлт гарсан. Эдийн засгийн өсөлт ийнхүү эрчээ авах зуур төсвийн болон төлбөрийн тэнцлийн алдагдал хумигдаж, Засгийн газрын өр бага зэрэг буурсан билээ. Дэлхийн банкнаас гаргасан энэ удаагийн тайлан эдгээр үзүүлэлтийг тодотгосон юм.

Тухайлбал, уул уурхайн салбар болон хувийн хэрэглээ сэргэж байгаагаас энэ оны эхний улиралд ч эдийн засгийн өсөлт сайн байсныг Монгол дахь Дэлхийн банкны Суурин төлөөлөгч Жэймс Андерсон онцлов. Эдийн засаг ирэх онд үргэлжлэн сайжрах төлөв харагдаж байна. Тус банкны зүгээс манай улсын богино болон дунд хугацааны эдийн засгийн хөгжлийг өөдрөгөөр зураглажээ. Гэхдээ хөдөлмөрийн бүтээмжээ нэмэгдүүлж, эдийн засгаа төрөлжүүлэхээс гадна оновчтой дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийснээр одоогийн амжилтаа цаашид хадгалж үлдэх боломжтойг тэд бас сануулаа.



Б.Батдорж / ЗГМ©

Эдийн засгийн өсөлт энэ онд зургаан хувь руу тэмүүлэхээр байгаа. Хэрэв төсвийн хөрөнгө оруулалтыг үр ашигтай зарцуулж чадвал эдийн засгийн өсөлт үүнийг давахаар байна. Уул уурхайн салбарт их хэмжээний гадаадын шууд хөрөнгө оруулалт үргэлжлэн орохоор хүлээгдэж байгаа. Гэхдээ хөрөнгө оруулагчдын эрх ашгийг төр засаг хамгаалж, хууль эрх зүйн орчин тогтвортой, тодорхой, хувийн өмчид хүндэтгэлтэй ханддаг болсноор эдийн засгаа өөд нь татах нөхцөл илүү бүрдэнэ гэдгийг Дэлхийн банк бататгав.

Өсөлт бий болоход уул уурхайн салбар голлон нөлөө үзүүлэхээр байна. Дэлхийн банкны зүгээс төсвийн хөрөнгөөр хийгдэж буй улсын хөрөнгө оруулалтын хяналт, удирдлага сул байгааг шүүмжилсэн юм. Энэ нь төсвийн алдагдал нэмэгдэх ээлжит шалтгаан болж байна. Төсвийн

хөрөнгө оруулалтын бодлого сүүлийн жилүүдэд алдагдаж эхэлсэн. Үүний гор эдийн засагт өр, дарамт зэрэг авчирсан юм. Үүнд Засгийн газар анхаарахгүй бол царцсан барилга, байгууламж олшрох сул талтай билээ. Энэ нь хөрөнгө оруулалт үнэгүйдэхэд хүргэдэг.

Гадаадын хөрөнгө оруулалтыг “Оюутолгой”-н хөрөнгө оруулалт тодорхойлж байна

Манай улсын хөрөнгө оруулалтыг бүс нутгийн орнуудтай харьцуулахад нэлээд өндөр дүнтэй гарсныг Дэлхийн банк-

наас дуулгасан юм. 2017онд гэхэд ДНБ-ий 37 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалт манай улсад хийгджээ. Гэвч улсын салбарын хөрөнгө оруулалтын үр ашиг бүс нутгийн орнуудтай харьцуулахад маш доогуур байгааг Дэлхийн банк анхааруулсан юм. Энэ байдал нь улсын өрийг нэмэгдүүлж, цаг хугацаа алдахад хүргэдэг гэв. Улсын салбарын хөрөнгө оруулалтын бодлого, шийдвэр гаргалтаа эргэж харж сайжруулах шаардлагатайг Дэлхийн банкны Монгол Улсыг хариуцсан ахлах эдийн засагч Жон Паскаль Нгану онцолсон юм.

2015 он хүртэл эрчимтэй нэмэгдэж, төсвийн алдагдал, улсын төсвийн өр ихээхэн нэмэгдэхэд нөлөөлсөн улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн сүүлийн таван жилийн хэрэг-жилтийг нарийвчлан авч үзсэн байна. Цаашид төслийг нэн

шаардлагатай, шаардлагатай гэх мэтээр сонгох, эрэмбэлэх тодорхой шалгуур үзүүлэлттэй байх нь илүү үр дүнтэйг Дэлхийн банкныхан хэлсэн юм.

Хэдийгээр эдийн засагт гэгээтэй үзүүлэлт олон байгаа боловч эмзэг байдал хэвээр байгааг сануулсан. Түүхий эдийн зах зээлээс манай улсын эдийн засаг бүхэлдээ үлэмж хамраалтай байгаа нь хямрал, хүндрэл хол биш гэдгийг Дэлхийн банк энэ удаа дахин анхааруулсан юм. Эдийн засгаа төрөлжүүлэх ач холбогдлын талаар тус банк тайлан болгондоо байнга хэлж, ярьж ирсэн. Үүнийг бодлогодоо тусгах учиртайг мөн захилаа.

Гадаадын хөрөнгө оруулалтыг “Оюутолгой” төслийн хоёр дахь шатны хөрөнгө оруулалт тодорхойлж байна. Хэрэв “Тавантолгой” төсөл энэ ондоо багтан хөдөлж чадвал хөрөнгө оруулалтын орчинд эерэг дохио болохоор байгаа юм. Төсвийн хувьд Сангийн яам болон Засгийн газарт хамаарах бодлогын зөвлөмжийг Дэлхийн банк өгсөн бол мөнгөний бодлого чангарч болзошгүй гэв. Учир нь, хүнс, шатахууны үнэ үргэлжлэн өсөх эрсдэл байгаа нь инфляцыг цаашид алгуур өсгөх шалтгаан болохоор байна. Мөн хувийн хэрэглээ үргэлжлэн өсөхөөр байгаа тул төв банк инфляцыг хянахын тулд мөнгөний бодлогоо өөрчилж магадгүй нь. ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” нь Дэлхийн банкны хувьд манай улсын эдийн засгийн төсөөллийг гэгээтэй өнгөөр “будах” гол шалгуур болсон байна. [ЗГМ]

мөнгөний бодлого


Инфляц 2018 оны турш нам түвшинд тогтвортой байна

Эрэлтийн шинжтэй инфляц алгуур нэмэгдэх төлөвтэй

Б.Мөнх  
ЗГМ

Монголбанк инфляцын төлөв байдлын ээлжит тайланг танилцууллаа. Улсын хэмжээнд инфляц зургаан хувьтай тэнцэж байна. Энэ нь төв банкны зорилтот түвшнээс хоёр нэгжээр доогуур үзүүлэлт юм. Тэгвэл оны турш инфляц нам

түвшинд тогтвортой байна гэж Монголбанк үзэж байна. Гэхдээ эдийн засгийн сэргэлттэй холбоотой эрэлтийн шинжтэй инфляц алгуур нэмэгдэхээр байгааг дээрх тайланд дурджээ. Хэдий тийм боловч инфляц энэ оны турш харьцангуй тогтвортой байж, зорилтот түвшний орчимд хадгалагдах төлөвтэйг онцлов. Эдийн засгийн тусгал болж байдаг инфляц шатахуун, суудлын автомашин, хүнсний ногоо, согтууруулах ундаа, тамхи, цаг агаар болон татварын өөрчлөлтийн нөлөөгөөр нэмэгдсэн. Тайлант хугацаанд эрэлтээс өндөр хамааралтай бараа, бүтээгдэхүүн болох хувцас, үйлчилгээ болон зарим хүнсний



үнийн өсөлт бага байжээ. Ирэх онд уул уурхайн бус салбарын идэвхжилтэй холбоотойгоор хүнсний бус инфляц бага зэрэг өсөх бол хүнсний инфляц ялимгүй буурах төсөөлөлтэй

байна.

Монголбанк бодлогын хүүгээр дамжуулан хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг эдийн засгийн өсөлтийг тэтгэх хэмжээнд байлгахаар зорьж

байгаа юм. Инфляц нам түвшинд байснаар иргэдийн бодит орлого, хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалж, банк санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг бэхжүүлдэг. Тэрчлэн урт хугацаанд хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмждэг ач холбогдолтой.

Мөнгөний бодлого инфляцыг онилох арга хэлбэрт аажмаар шилжиж буй. Зах зээлд оролцогчдын итгэл сэргэж, уул уурхайн салбарт бүтээн байгуулалт үргэлжлэн, гадаад орчин таатай байгааг инфляцын тайланд цохон тэмдэглэжээ. Хөрөнгө оруулалт, өрхийн хэрэглээ, экспортын өсөлт нь эдийн засгийн өсөлтийг эрэлт талаас нь дэмжсэн байна. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» ТҮҮХИЙ ЭД

0.2

Хувь. West Texas төрлийн газрын тосны ханш 0.2 хувиар өсөж, баррель нь 72.82 ам.доллар давлаа.

» УУЛ УУРХАЙ

0.3

Хувь. Алтны ханш олон улсын зах зээлд 0.3 хувиар буурч, унц нь 1245 ам.долларт хүрэв.

» ТАВААР

1.7

Хувь. Лондоны металлын биржид зэсийн ханш огцом буюу 1.7 хувиар уналаа. Ингэснээр тонн зэсийн ханш 6237 ам.долларт хүрсэн байна.

» ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

АНУ-ын шинээр ажилд орсон биржид зэсийн ханш огцом сард 195 мянгад хүрсэн байна. Энэ нь тавдугаар сарын дүнтэй харьцуулахад 30 мянгаар буурсан үзүүлэлт аж.

» ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

4.4

Сая. “Хөвсгөл алтан дуулга” нэг бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 4.4 сая ширхэг нэмэлт хувьцааг бүртгэлээ.

» ДААТГАЛ

1.7

Тэрбум төгрөг. “Анд ДД” компани энэ онд зургаан даатгалын компанитай хамтран давхар даатгалын үйл ажиллагаа явуулж, татварын дараа 1.7 тэрбум төгрөгийн, 2020 он гэхэд хамтран ажиллагч компанийхаа тоог хоёр дахин нэмэгдүүлж 3.9 тэрбум төгрөгийн ашигтай ажиллах бизнес төлөвлөгөө боловсруулсан байна.

ВАЛЮТЫН ХАНШ

|               |          |
|---------------|----------|
| АНУ-ын доллар | 2,463.31 |
| Евро          | 2,882.81 |
| Японы иен     | 22.28    |
| ОХУ-ын рубль  | 39.03    |
| БНХАУ-ын юань | 370.35   |
| БНСУ-ын вон   | 2.20     |

НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААНД УРЬЖ БАЙНА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 299 дугаар тогтоолоор дараах автомашинуудыг дуудлагын худалдаагаар худалдахаар шийдвэрлэв.

1. Дуудлагаар худалдах хөрөнгийн танилцуулга:

Краз кран нь 1994 онд үйлдвэрлэгдсэн ДЦС-4 ТӨХК-н ачаа өргөх, зөөхөд 25 жил ажилласан, сэлбэг үйлдвэрлэл зогссон олдпохгүй болсон, краны үндсэн үйл ажиллагаа алдагдсан.

Авто ачигч нь ОХУ-д үйлдвэрлэгдсэн, үйлдвэрлэл хаагдсан тул сэлбэг олдохгүй, үндсэн ажиллагаа алдагдаж ашиглах боломжгүй болсон.

| № | Автомашинны марк, улсын дугаар, зориулалт   | Үйлдвэрлэгдсэн он | Нийт гүйлт | Худалдаалах доод үнэ /төгрөг/ |
|---|---------------------------------------------|-------------------|------------|-------------------------------|
| 1 | Краз кран,47-65 УББ,тусгай зориулалтын      | 1987/1994         | 20500      | 4,000,000₮                    |
| 2 | Авто ачигч модель, 42-14УБ тусгай зориулалт | 1994/2003         | 19450      | 800,000₮                      |

2. ДУУДЛАГЫН ХУДАЛДААНЫ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

|                                                 |                                                                                                     |
|-------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------|
| Дуудлагын худалдаа болох хугацаа                | 2018 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 10 цагт                                                        |
| Дуудлага худалдаа болох газар                   | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын хурлын танхимд                                           |
| Дуудлагын худалдаанд тавих дэнчингийн хэмжээ    | Худалдаалах доод үнийн 25%                                                                          |
| Худалдах, худалдан авах гэрээний ерөнхий нөхцөл | Худалдан авагч нь дуудлагын худалдаагаар худалдан авсан эд хөрөнгийн үнийг 14 хоногийн дотор төлнө. |
| Дэнчин байршуулах данс                          | Хүлээн авагч байгууллага: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын кассанд бэлэнээр тушаана       |

3. ДУУДЛАГЫН ХУДАЛДААНД ХҮСЭЛТ ИРҮҮЛЭХ

Дуудлага худалдаанд оролцох хүсэлтийг 2018 оны 08 дугаар сарын 10 өдрийн 0930 цаг хүртэл Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 214 тоот өрөөнд хүлээн авна. Хугацаа хоцорсон хүсэлтийг хүлээн авах боломжгүйг анхаарна уу.

Дуудлага худалдаанд оролцох хүсэлт нь зөв, цэвэр бөглөгдсөн худалдаанд оролцох хүсэлтийн маягт, дэнчин төлснийг нотлох баримт, иргэний үнэмлэх (хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэлийн гэрчилгээ)-ийн хуулбар зэрэг баримтаас бүрдэнэ.

4. ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ АВАХ

Дуудлагаар худалдах хөрөнгийг өмч эзэмшигч Дулааны 4-р цахилгаан станц ТӨХК дээр очиж үзэж болох бөгөөд дуудлагын худалдааны журам, бүртгэх хугацаа, хөрөнгийн талаарх мэдээллийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 62263018 утсаар болон цахим хуудаснаас авна уу.

Хаяг: Улаанбаатар хот. Баянгол дүүрэг 20-р хороо, Эрчим хүчний гудамж Холбогдох утасны дугаар 70005813, 99040783

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕНДЕРИЙН ЗАРЛАЛ

2018.07.09

“ДЦС-4” ТӨХК нь БАЙГАЛЬ ОРЧНЫ НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ-г хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Энэхүү зөвлөх үйлчилгээ нь “ДЦС-4” ТӨХК-ийн эзэмшил бүхий нутаг дэвсгэр дээр 2018 оны 8-аас 10 дугаар сарын хооронд Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгэх зөвлөхийг сонгон шалгаруулах цахим тендер.

Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох

- Компанийн танилцуулга, үүсгэн байгуулагдсан түүх
- Санхүүгийн аудитлагдсан тайлан 2016,2017 он
- Туршлагын мэдээлэл /гэрээ, гэрээний дүгнэсэн акт,захиалагч байгууллагын тодорхойлолт хамт/ сүүлийн 3-н жил /2015,2016,2017/
- Ажиллах хүчний мэдээлэл /гэрээний хуулбар, анкет, диплом, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар /
- Улсын бүртгэлийн гэрчилгээ
- Тусгай зөвшөөрлийн хуулбар
- Татварын хэлтсийн цахим тодорхойлолт
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн төрөлжсөн архивын тодорхойлолт
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт
- Харилцагч бүх банкны тодорхойлолтыг ирүүлнэ.

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2018 оны 07 дугаар сарын 20-ний 10 цаг 00 минут хүртэл авч болох бөгөөд мэдүүлгээ дор дурдсан хаягаар 2018 оны 07 дугаар сарын 24–ны 10 цаг 00 минутын дотор ирүүлнэ үү.

“ДЦС-4” ТӨХК ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС  
Улаанбаатар хот Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж  
“ДЦС-4” ТӨХК-ний Захиргааны байр, 3-р давхар 311, 312 тоот өрөө, Утас: 70181309, Мэргэжилтэн Б.Мөнхнаран







# Худалдааны тариф ханган нийлүүлэлтэд муугаар нөлөөлнө

Люси Хорнби, Арчи Жан

Хятадад үйлдвэрлэсэн 34 тэрбум ам.долларын бараа бүтээгдэхүүнд баасан гарагаас тарифын шинэ журам үйлчилж эхэллээ. Шинэ тариф нь геополитикийн өрсөлдөгч гэж тооцох болсон улсаас АНУ-ын ханган нийлүүлэх сүлжээ хамаарадаг явдлыг зогсоох стратегийн эхний алхам юм.

АНУ-ын тариф нь өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг бараг хөндсөнгүй. Жишээ нь, Apple дэлхийн хамгийн их захиалгат үйлдвэрлэгч Foxconn хэмээх хятад компаниас бараг бүрэн хараат атлаа iPhone утсыг шинэ татварт оруулсангүй. Бөс даавуу, хүүхдийн тоглоом гэх мэт супермаркетын тавиураас худалдан авч болдог бүхэн хямд хэвээр үлдсэн тул АНУ-ын хэрэглэгчид үнийн шошго хараад цочих хэрэг гарахгүй юм.

Гэхдээ үйлдвэрлэлийн сүлжээ нь хоёр улс дамждаг хагас дамжуулагчийн салбарт энэхүү шинэ тариф ноцтой уршигтай. Мөн Хятадын цөмийн эрчим хүч үйлдвэрлэлийн салбарт тулгуурлан АНУ-ын шинэ реакторуудыг хямд аргаар бүтээх санаа ч замхрах тийшээ боллоо.


Хэрэг дээрээ тариф нь үйлдвэрлэгчдийг, ялангуяа тоног төхөөрөмж, эд анги үйлдвэрлэгч-



дийг ханган нийлүүлэх сүлжээгээ “дотоодод эргүүлэн татах”-д хүргэнэ. Цагаан ордон дахь эдийн засгийн үндсэрхэг үзэлтнүүд “Made in America” брэндүүд хүртэл хилийн чанадаас гаралтай хямд эд ангиас хамааралтайг андахгүй. Чухам уг нөхцөл нь Дэлхийн II дайн, хүйтэн дайны үеэр хэрэгжүүлсэн бодлогоо АНУ давтах шаардлагатайг харуулж байна хэмээн үндсэрхэг үзэлтнүүд үздэг. Ерөнхийлөгч Дональд Трампын бууруулахаар амласан ужиг шинжтэй худалдааны алдагдлыг ч тооцох ёстой.

Дэлхийн санхүүгийн хямралаас хойш хоёр улсын худалдаанд цахим хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжийн эзлэх хувь хэмжээ тогтвортой өссөөр ирлээ. Тариф чухам энэ хоёр салбарт илүү хөнөөлтэй юм.

Хэрэглэгчид тэр бүр харагддаггүй эд анги, тоног төхөөрөмж, машин механизмын “үл үзэгдэгч” чанараас шалтгаалан тариф дээрх хоёр салбарт хэр нөлөөлөхийг тооцоолох нь түвэгтэй. Жишээ нь, АНУ-ын автомашин үйлдвэрлэгчдэд шинэ тарифын нөлөө бага. АНУ-ын зах зээлийн



20 хувийг эзэлдэг гаднын автомашинууд дотор Хятадаас орж ирдэг нь харьцангуй цөөн. General Motors Хятадаас Buick Envision хэмээх ганц загварыг АНУ-д оруулдаг нь тус компанийн нийт борлуулалтын 1.5-хан хувийг эзэлдэг. Гэхдээ Цагаан ордон одоогоор хэрэгжүүлээгүй байгаа автомашины эд ангид татвар оноох сүрдүүлгээ бодитой болговол ерөнхий дүр зураг шууд өөрчлөгдөнө. “Үйлдвэрлэгчид үйлдвэрээ АНУ-д шилжүүлэх замаар автомашины татвараас бултаж болно. Харин эд ангид


тариф тогтоочихвол бултахад хэцүү. “Эд ангийн экспорт асар том цар хүрээтэй”-г Шанхай дахь Automobility Ltd консалтинг компанийг үндэслэгч Билл Руссо анхааруулав. БНХАУ-ын гаалийн статистикаас үзвэл тус улс 2017 онд АНУ-д автомашины есөн тэрбум ам.долларын эд анги нийлүүлжээ. Гэхдээ уг статистикт үндсэндээ Хятадад үйлдвэрлэж буй резин дугуйг оруулаагүй. Оруулж тооцвол дахиад хоёр тэрбум ам.доллар нэмэгдэнэ. БНХАУ-д автомашины эд ангийн үйлдвэр бүхий олон улсын

33 үйлдвэрлэгчийг China Automotive Information Net хэмээх төрийн мэдлийн вэбсайт бүртгэж буй. Хятадын дотоодын эд анги үйлдвэрлэгчид ч АНУ-ын зах зээлд нэвтрэх зорилготой. Wanxiang зэрэг зарим компани АНУ-ын үйлдвэрт хэдийнэ хөрөнгө оруулсан. Хөрөнгө оруулсан шалтгаан нь дэлхийн хамгийн хурдацтай тэлж буй авто зах зээлд 1990-ээд оноос эхлэн угсрах үйлдвэрүүдээ байгуулсан америк үйлдвэрлэгчдийг эд ангиар хангахын тулд юм. Цонхны шил, эрэг шураг, сэлгүүр зэргийг Хятадаас сонгох нь автомашин үйлдвэрлэгчдэд төдийгүй тэднийг эд ангиар ханган нийлүүлэгчдэд ч ашигтай. “Автомашин үйлдвэрлэлийн ханган нийлүүлэх сүлжээ хэрэгцээт эд ангийг хямд төсөр үйлдвэрлэж чаддаг улсуудад шилжсэн”-ийг ноён Руссо анхааруулав.

Үйлдвэрлэлийн “дотоодлоо эргүүлж татах” бодлого АНУ-ын үйлдвэрлэгчдийн зардлыг өсгөнө. АНУ-ын Үйлдвэрлэгчдийн үндэсний холбооноос (National Association of Manufacturers) саяхан явуулсан судалгаагаар үйлдвэрлэлийн зардал болон борлуулах үнэ ирэх онд тав орчим хувиар өсөх дүн гарчээ.



## Азийн хөрөнгийн биржүүдийн долоо хоногийн хаалт



# Хойд Солонгосоос зугтагсад Кимийн хуурах аргыг илчлэв

Брайн Харрис

АНУ болон Хойд Солонгосын дээд хэмжээний уулзалтаас хойш ноён Трамп Умардын дэглэмийн зэвсэглэлийг хураах хэлэлцээ амжилттай явагдаж буйд сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлсэн. Гэвч АНУ-ын Ерөнхийлөгчийн урам зоригийг хуваалцахгүй байгаа хүмүүс бол Хойд Солонгосыг хамгийн сайн мэдэх тус улсын иргэд юм. Пхеньяны дэглэм дор амьдарч, дарлагдаж зовсон хүмүүс дипломат яриа хэлэлцээг утаа, хөшиг төдий зүйл, залуу удирдагч хэзээ ч цөмийн зэвсгээ өгөхгүй гэдэгт итгэлтэй байна.

Пүрэв гарагт АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Майк Помпео Пхеньянд ирж, дээд



уулзалтаар тохиролцсон “цөмийн зэвсгийг бүрэн хураах” асуудлыг хэллцэнэ. Ноён Помпео таатай цаг үеийг ашиглан Умардын цөмийн

зэвсэг болон байгууламжуудыг буулгах тусгай хуваарь гаргах бодолтой байгаа. Гэвч хүмүүсийн найдвар багассаар байна. Хойд

Солонгосоос зугтан гарсан Хеонсо Ли ноён Кимд зөвхөн эдийн засгийн дэмжлэг хэрэгтэй гэжээ. Ким засгийн эрхэнд гарсны эхний жил буюу 2012 онд Умардаас зугтсан Пак Мижха “Ким Жон Ун хэзээ ч цөмийн зэвсгээсээ татгалзахгүй” хэмээв. Ийм үг яриа Америкийн тагнуулын албадын Пхеньянд үл итгэх байр суурьтай нийцж буй. Бүс нутагт улс төрийн дулаарал ажиглагдаж буйг үл харгалзан өнгөрсөн долоо хоногт Хойд Солонгос баллистик пуужин ба цөмийн чадамжаа дээшлүүлэх туршилт хийсээр байгаа тухай мэдээ тарсан. Пхеньян яриа хэлэлцээг сунжруулж, эдийн засгийн буулт шаарддаг ур хугацааны стратегид Вашингтон урхидуулах

вий гэсэн болгоомжлол нэмэгдлээ. The Girl with Seven Names: A North Korean Defector’s Story хэмээх 2015 оны бестселлер номын зохиогч ноён Хеонсо “Маш олон хүн төөрөлдөж байна. Кимд эдийн засгийн дэмжлэг л хэрэгтэй. Өмнөд Солонгос түүнийг өгөхөөр бэлтгэж байна” гэсэн юм. Судлаачдын таамагласнаар Хойд Солонгос пуужин үйлдвэрлэх байгууламжаа өргөтгөж буй. Умардын дэглэм өөрчлөгдөж буй орчин, цаг үед зохицуулан ухуулга сурталчилгаагаа шинэчилж байна. Пхеньяны хэвлэл, мэдээлэлд АНУ ба Өмнөд Солонгосыг үргэлж шүүмжлэх хандлага өнгөрсөн саруудад зогссон нь жинхэнэ

өөрчлөлтийн найдвар төрүүлсэн юм. Гэвч Өмнөд Солонгосын чөлөөнд гарсан офицер хэлэхдээ “Одоогийн дулаарал бол Кимийн хувьд шоу, Трампын хувьд 11 дүгээр сарын дунд хугацааны сонгуулийн өмнөх улс төрийн стратеги төдий зүйл” хэмээв.

Сөүлд эсэргүүцлийн бүлэгт ажилладаг Хойд Солонгосын дүрвэгч Пак Сан Хак дээрх бодолтой санал нэг байна. Тэрбээр “Хэрэв ноён Помпео Умардыг цөмийн зэвсгээ бүрэн хураахыг ятгаж чадахгүй бол Пентагон уг асуудалд оролцоно гэдэгт итгэж байна” гэжээ. Энэ үг Помпеогийн Пхеньянд хийж буй айлчлалын гүнзгий учир холбогдлыг илэрхийлнэ.



## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 07 дугаар сарын 09

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: “Агаарын хөлгийн техник үйлчилгээний багаж тоног төхөөрөмж” нийлүүлэх** тендер нь дараах 7н багцтай.

БАГЦ 1 “Гурван цэгийн микрометр / Three point inside micrometer”  
БАГЦ 2 “Хэт авиан цэвэрлэгээний машин /Wheel halves ultrasonic cleaning machine”  
БАГЦ 3 “10,000Psi/70MPa хүртлэх агаарын манометер шалгаж баталгаажуулах төхөөрөмж”  
БАГЦ 4 “Ангарын шалыг угаах зориулалтын машин”  
БАГЦ 5 “Агаарын хөлгийн хивсэндэр болон зөөлөн эдлэл цэвэрлэх машин, тоног төхөөрөмж”  
БАГЦ 6 “Хэмжилтийн кабинетын тоног төхөөрөмж”  
БАГЦ 7 “Үл эвдэх сорилын багажны иж бүрдэл”

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР:** МИАТ/201807217

МИАТ ХК эрх бүхий тендерт оролцогчдоос 7 багц бүхий агаарын хөлгийн техник үйлчилгээний тоног төхөөрөмж нийлүүлэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерт оролцогч нь эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50000 төгрөг**, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендерийн баримт бичгийн [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайтад байршуулсан болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

**Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилийн аль нэгэн жилд нь борлуулалтын орлого нь санал болгож буй үнийн дүнгээс 100%-аас багагүй /2016он, 2017он/  
**Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо:** Сүүлийн 1 жил /2017он/  
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн 80%-аас багагүй байна.

**Тендерийн хамт**  
БАГЦ 1 1,500,000 төгрөг /нэг сая таван зуун мянга/  
БАГЦ 2 3,000,000 төгрөг / гурван сая/  
БАГЦ 3: 22,50000 төгрөг /хоёр сая хоёр зуун тавин мянга/  
БАГЦ 4: 380,000 төгрөг / гурван зуун наян мянга/  
БАГЦ 5: 180,000 төгрөг / нэг зуун наян мянга /  
БАГЦ 6: 3,120,000 төгрөг /гурван сая нэг зуун хорин мянга/  
БАГЦ 7: 2,000,000 төгрөг /хоёр сая/ тус тус тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2018 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 13.00 цаг –аас өмнө** Цахим худалдан авах ажиллагааны систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) –д цахим хэлбэрээр ирүүлнэ тендерийг **2018 оны 08 дугаар сарын 10-ний өдрийн 13.20 цаг -т** цахимаар нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй**  
**Дотоодны давуу эрх тооцохгүй**  
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**МИАТ ТӨХК Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, Буянт-Ухаа, МИАТ ТӨХК-ийн төв байр**  
**Хангамж, үйлчилгээний хэлтсийн 103 тоот өрөө**  
**Утас: 70049860, 99021781 Факс: 70049919**

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 07 дугаар сарын 09 ны өдөр

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:** Мах нийлүүлэх  
**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР:** MC-2018/112

“ДЦС-4” ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос Мах нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна. Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө **50.000 /Тавин мянга/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн дотор** хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

**1. Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилийн жил тус бүрийн борлуулалтын орлого нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. 2016,2017 он тус бүрээр  
**2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.  
**3. Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** сүүлийн 2 жил. 2016, 2017он  
**4. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Тендерт санал болгосон үнийн дүнгээс багагүй байх /2016, 2017 он /

Тендерийн хамт **12,645,000** дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгааг хүлээн зөвшөөрнө.

Хүчинтэй байх хугацаа: **2018 оны 10 дугаар сарын 22 -ний өдөр дуустал**

Тендерийг **2018 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн 10.00 цагаас өмнө** цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2018 оны 08 дугаар сарын 09 –ны өдрийн 10 цаг 30 минутад** нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй**

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж, “ДЦС-4” ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар, 310 тоот өрөө** Худалдан авах ажиллагааны хэлтэс  
**Утас 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс 7018-1309 7000-1357**



# Өдрийн хэмнэл

## ЗУРХАЙ



### Билгийн тооллын 26

Зуны дунд шар морь сарын таван шар мэнгэтэй хар бар өдөр.

**Үс засуулбал:** Жаргал үргэлжид ирнэ

**Наран ургах, шингэх:** 05.08-20.51

**Барилдлага:** Үхэх

**Шүтэн барилдлага:** Хурьцахуй

**Суудал:** Мод

### Аргын тооллын долдугаар сарын 9, Сумъяа гараг. Билгийн тооллын 26, нэгэн эхийн зургаан хөвгүүн одтой, хар бар өдөр.

Өдрийн наран 05.08 цагт мандан, 20.51 цагт жаргана. Тухайн өдөр морь, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, сүм дуганыг сэргээх, амилуулах, өглөгийн түллэг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, гэр, байшингийн суурь тавихад сайн. Золиг гаргах, бомбын үйл, гөлөг тэжээхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой.

## ЗГМ: СҮДОКУ

|   |   |   |   |   |   |   |
|---|---|---|---|---|---|---|
|   |   |   | 8 |   | 7 | 3 |
| 6 |   |   | 7 | 4 | 1 |   |
| 4 |   | 9 | 2 |   |   |   |
| 8 |   |   |   |   |   |   |
| 1 |   |   | 3 | 5 | 4 |   |
|   |   |   |   |   |   | 9 |
|   |   |   | 4 |   | 5 | 1 |
|   | 3 | 2 | 1 |   | 9 |   |
|   | 4 |   |   |   | 8 | 9 |
|   |   |   |   |   |   | 6 |

|   |   |   |   |   |   |   |   |   |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 3 | 8 | 6 | 7 | 9 | 5 | 2 | 4 |
| 4 | 6 | 2 | 1 | 3 | 5 | 9 | 7 | 8 |
| 9 | 7 | 5 | 4 | 2 | 8 | 6 | 3 | 1 |
| 3 | 1 | 7 | 9 | 6 | 2 | 4 | 8 | 5 |
| 8 | 5 | 9 | 7 | 1 | 4 | 3 | 6 | 2 |
| 2 | 4 | 6 | 5 | 8 | 3 | 7 | 1 | 9 |
| 7 | 8 | 4 | 2 | 9 | 6 | 1 | 5 | 3 |
| 6 | 9 | 3 | 8 | 5 | 1 | 2 | 4 | 7 |
| 5 | 2 | 1 | 3 | 4 | 7 | 8 | 9 | 6 |

(Өмнөх дугаарын хариу)



### Монгол хувцасны “Нууц товчоо”-нд

**Хаана:** Чойжин ламын сүм музей

**Хэзээ:** 2018.07.09-ний 20.00 цагт

**Тасалбарын үнэ:** ₮ 80 мянга



### Цагаан лавай чуулгын

#### “Нүүдэлчний аялгуу” тоглолт

**Хаана:** МТЗ-ын дуу бүжгийн чуулга

**Хэзээ:** 2018.06.22-07.15-ны өдөр

**Тасалбарын үнэ:** ₮ 20 мянга



### Hotel Transylvania 3: “Зуны амралт”

#### хүүхэдэйн кино

**Хаана:** “Өргөө” (IMAX)

**Хэзээ:** 2018.07.11-нээс

**Тасалбарын үнэ:** ₮ 10-25 мянга

## ОНЦЛОХ ҮЗВЭР

# Урлагаар анагаах “Өнгөт өдөр”



Улсын гуравдугаар төв эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй өвчтөнүүдийн сэтгэл санаа, өөртөө итгэх итгэлийг дэмжихэд чиглэсэн “Өнгөт өдөр” уран зургийн өдөрлөг долдугаар сарын 16-18-ны хооронд зохиогдох гэж байна. АНУ-ын “Хоспитал Арт” сангийн төлөөлөгчид

энэхүү үйл ажиллагааг зохион байгуулах юм. Энэ үеэр Арт терапевст урлагийн сэтгэлзүйчид хэвтэн эмчлүүлэгсдийг зургийн сургалтад хамруулж, шилдэг бүтээлээр нь үзэсгэлэн гаргах аж. Монголын урлагийн зөвлөл анх 2014 онд Америкийн талтай хамтран

art therapy буюу “урлагаар анагаахуй” эмчилгээний аргыг нэвтрүүлсэн нь амжилттай болсон юм. Урлагийн сэтгэл засал гэх нэр томъёо нь бидэнд шинэ зүйл мэт сонсогдож магадгүй ч сэтгэл заслын энэ төрөл дэлхий нийтэд хөгжөөд 100 гаруй жил болж байгаа юм. [31W]



### “Монголын сайхан орон” тоглолт

**Хаана:** УДБЭТ

**Хэзээ:** 2018.07.11-нд

**Тасалбарын үнэ:** ₮ 30-40 мянга



### Улсын Филармонийн үзвэрийн 47

#### дахь жилийн нээлтийн тоглолт

**Хаана:** Улсын филармони

**Хэзээ:** 2018.10.12-ны 19.00 цагт

**Тасалбарын үнэ:** ₮ 25 мянга



### Хүн шоргоолж 2 кино

**Хаана:** “Өргөө” (IMAX)

**Хэзээ:** 2018.07.06-наас

**Тасалбарын үнэ:** ₮ 10-25 мянга

## ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ

|    |    |    |    |    |    |
|----|----|----|----|----|----|
| 1  | 2  | 3  | 4  | 5  | 6  |
| 7  | 8  | 9  | 10 | 11 | 12 |
| 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 |
| 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 |

### БОСООГООР:

- Олон үеийн удамт арслан, ОУУХМ
- Монголчууд эртнээс

- хэрэглэж ирсэн, хамгаалах утга бүхий зан үйл
- ... нуйгүй (илэн далангүй)
- Киви хамтлагийн дуучин

- Австрали тивийн олонх амьтдын биед байдаг зүйл
- МУУГЗ, нэрт найруулагч
- Үндэсний бөхийг бүртгэж, эрэмбэ, оноолт гаргагч (гарын...)
- Нэгэн бүл цэцэг
- Агаар мандал дахь усны уур жижиг мөсөн талст болон газарт буудаг хур
- ...үзэсгэлэн
- Өршөөнгүй, энэрэнгүй
- ... нүгэл
- Наадмын бэлтгэлд

- гардаг бөхчүүдийн бүлгийг нэрлэх нь
- Японы мөнгөний нэгж
- Юмны хамгийн чанар сайтай хэсэг

### ХӨНДЛӨНГӨӨР:

- Баяр наадамдаа хамгийн олон удаа түрүүлсэн "Амгалан төрийн ажнай хүлэг" шарга азарганы эзэн
- Гарлаа, давлаа аварга гэгдсэн дархан аварга

- агсан
- Говь-Алтай аймгийн Ардын дуу бүжгийн чуулгын нэр
- Дайчин вангийн хүч их бөх, "хулгар" хэмээх шилийн сайн эр
- Увс аймгийн харъяат хүчит заан
- ... ов, самбаа
- Улсад нэг түрүүлж, хоёр үзүүрлэсэн "Мөнгөн морьтын" хэмээх арслан
- ОХУ-2018 ДАШТ-д

- оролцох эрхээ авч чадаагүй, дэлхийн дөрвөн удаагийн аварга улс

- Сүхбаатар аймгийн "нийгмийн" хэмээн алдаршсан хурдан хүлгийн зүс

### Өмнөх дугаарын хариу / 07.06

|   |   |   |   |   |   |   |   |   |   |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Б | А | Н | Ь | Д | Х | Э | Р | Э | Х |
| А | У | У | И | О | А |   |   |   |   |
| Т | Ө | М | Ө | Р | Б | А | Т | А | Р |
| М | Н | Н | А | Я | Ү |   |   |   |   |
| Ө | Н | Д | Ө | Р | Г | О | Н | Г | О |
| Н | Э | Т | Р | О | Э |   |   |   |   |
| Х | А | С | А | Р | Т | Ү | Л | Э | Э |

# ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо: 2018.07.09-ний өдөр**

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР:** Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, Эрдмийн өргөө цогцолбор сургууль/”-ийн ажил

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР:** НХААГ-18/0022

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендерт оролцогчдоос Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, Эрдмийн өргөө цогцолбор сургууль/”-ийн ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж цахим тендерийн баримт бичиг болон холбогдох материалыг татаж авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө тендерт оролцох хураамж болох 50 000 (тавин мянга) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Байгууламжийн зураг, төсөл боловсруулах, барих, түүний тоног төхөөрөмжийг хүргэх, суурилуулах ажлын нийт мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлтийг нь тооцох жилийн тоо:** Сүүлийн 3 жил буюу 2015, 2016, 2017 онуудын аль 1 жилийн борлуулалтын орлого нь төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна.
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх.
- Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 3 жил /2015, 2016, 2017 он/-ийн аль нэг жилд төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байна.
- Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 3 жил буюу 2015, 2016, 2017 оны жилийн эцсийн баталгаажуулсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ.
- Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:** Тийм

**Зураг төсөл боловсруулах байгууллага нь:** Барилга, хот байгуулалтын яамны: **1.2.1, 1.2.4, 1.2.5, 1.2.6 эсвэл; 3Т-3.1, 3Т-3.3, 3Т-6.1, 3Т-6.2, 3Т-6.3, 3Т-6.4, 3Т-11.2**  
**Барилга угсралтын ажил гүйцэтгэх байгууллага нь:** Барилга, хот байгуулалтын яамны: **2.1.1, 2.1.2, 2.2.1, 2.2.2 эсвэл; БА-3.1, БА-6.1, БА-6.2, БА-6.3, БА-6.4, БА-8.1**

**Тендерийн баталгааны үнийн дүн:** 38,400,000 /гучин найман сая дөрвөн зуун мянган төгрөг/

Баталгааны хүчинтэй байх хугацаа **2018 оны 10 дугаар сарын 21**-ний өдрийг дуустал хүчинтэй байна.

Тендерийг **2018 оны 08** дугаар сарын **09**-ний өдрийн **08** цаг **00** минутаас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2018 оны 08** дугаар сарын **09**-ний өдрийн **08** цаг **20** минутаас минутад Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын тендерийн нээлтийн 1012 тоот өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй. Дотоодын давуу эрх тооцно. Сонирхсон этгээд холбогдох бусад мэдээллийг доорх хаягаар хандан авна уу.

**Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны IV байр, 10 давхарт**  
**Холбоо барих утасны дугаар: 75757807**  
**Цахим хаяг: [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.ub-procurement.mn](http://www.ub-procurement.mn)**

